

ОЛОН УЛСЫН ХАМТАРСАН ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИХ БОЛОМЖУУД (Ховд их сургуулийн жишээн дээр)

Б.Баярхүү¹

¹Ховд Их Сургууль
bayarhuub@yahoo.com

Хүлээн авсан огноо: 2021.10.22

Хэвлэхийн зөвшөөрсөн: Редакцийн зөвлөл, доктор Л.Нарантуяа

Үндэслэл

Ховд их сургуульд өнөөдрийн байдлаар бакалаврын болоод ахьсан түвшний 40 гаруй хөтөлбөрт 2500 орчим оюутан суралцаж байна. Эдгээрээс зарим мэргэжил нь гадаад орны их дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөрийн хүрээнд сургалт явуулдаг. 2003 оноос хойш Ховд их сургуульд Биологи, Газарзүй, Хими, Хэл шинжлэл, Түүхийн докторантурын түвшний сургалтуудыг явуулж эхэлсэн.

НЭГ: ERASMUS+ Дээд боловсролын байгууллагын чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Ховд их сургуульд “Байгаль орчны бодлого төлөвлөлт, менежмент, технологийн чиглэлээр докторын сургалтын хамтарсан хөтөлбөр боловсруулах нь” олон улсын хамтарсан төсөл хэрэгжиж байна.

Энэ төслийн зорилго нь

- Хамтрагч орны их дээд сургуулиудын хүрээлэн буй орчны бодлого, менежмент, технологийн чиглэлийн докторын хөтөлбөрүүдийг нэгтгэж судалгааны хамрах хүрээ, үйл ажиллагааны нийтлэг дүрэмд суурилсан үндэсний хэмжээний докторын хамтарсан сургуулийг бий болгох замаар докторын сургалтын практик ач холбогдол, мэргэшлийн ур чадварыг сайжруулах ба INTENSE олон улсын сүлжээгээр эдгээр докторын сургуулиудыг бэхжүүлэх,
- Одоогийн сургалтын агуулгыг нэгтгэх, уян хатан судалгаа сургалтын чиглэлийн хяналт, тогтолцоо ба хичээлүүдийг үнэлэх боломжийг бий болгох, судалгааны ур чадварыг үнэлж түгээх замаар докторын сургалтын орчныг бэхжүүлэх
INTENSE нь докторантуудын сургалтын хөтөлбөрийг олон сонголттой байх нөхцөлийг судлах цаашид хамтрагч орнуудын их дээд сургуулиудаас боловсруулж цуглуулсан олон нийтэд нээлттэй цахим хичээлийг мэдээлэлийн технологийн орчноор бий болгож боловсронгуй болгох боломжийг судлах, цахим сургалтын модулд ганцаарчилсан сургалтын багцыг бий болгох
- Докторантуудын чадавхийг бэхжүүлэх, судалгааны үр дүнг олон улсад болон Европын холбооны судалгааны сүлжээгээр

дамжуулан хэвлүүлэхийг нэмэгдүүлэх, хамтарсан судалгааг өргөжүүлэх, практикт чиглэсэн судалгааны сэдэвт ажил гүйцэтгэхэд туслан дэмжих зэрэг болно.

Төслийн хүрээнд

- Суралцагчдын судалгааны орчныг сайжруулах
- Докторын хамтарсан хөтөлбөрийн тодорхойлолт боловсруулах
- INTENSE олон улсын сүлжээг бий болгох
- Докторын хөтөлбөрийн судалгаа, сургалтын орчныг судлах, хамтран ажиллах
- Олон нийтэд нээлттэй цахим сургалтын модулыг бий болгох
- Түнш байгууллагуудын докторын хөтөлбөрийн оюутнуудыг харилцан туршлага судлах, чадавх бэхжүүлэх сургалтанд хамруулах зэрэг ажлууд хийгдэх болно.

Төслийн бүрэлдхүүнд Ази ба Европын 7 орны 11 их дээд сургуулийн баг хамт олон ажиллаж байна.

Төслийн хамтран ажиллагч их сургуулиуд:

Украин: Одессийн байгаль орчны их сургууль, Харьковын их сургууль, Украины ШУА-ийн Карпатын экологийн хүрээлэн

Монгол: Монгол улсын их сургууль, Ховд их сургууль

Вьетнам: Ханойн Байгалийн шинжлэх ухаан ба технологийн их сургууль, Хо Ши Миний байгалийн нөөц ба хүрээлэн буй орчны их сургууль

Европын холбоо: Естоны Хөдөө аж ахуйн их сургууль, Австрийн байгалийн нөөц ба хөдөө аж ахуйн их сургууль, Латвийн их сургууль

Нидерланд: Судалгаа, технологи, боловсролын Erda байгууллага

Төслийн үр дүнд

1. Ховд их сургуульд өндөр хүчийн чадал бүхий тоног төхөөрмжтэй ахьсан түвшний сургалтын танхимтай болсон.
2. Төслийн хүрээнд сургуулийн багш судлаачид, ахьсан түвшний оюутнуудыг хамарсан сургалтуудыг хамтран зохион байгууллаа.

Үүнд: Төв Европын их сургууль, Беларусь-Оросын сургууль, Эстонийн ХААИС, Укрианы

Одессийн байгаль орчны их сургууль, МУИС, Ховд их сургуулиудад цахим хичээл бэлтгэх, мэдээлэл харилцааны технологи, хүрээлэн буй орчин судлал, байгальд суурилсан ухаалаг хотуудын шийдэл, уур амьсгалын өөрчлөлт, цаг уур судлал, усны бодлогын инноваци зэрэг сэдвийн хүрээнд зуны сургалтуудад оролцлоо.

3. Залуу судлаачдын судалгааны ажлын хэлэлцүүлгийг улирал бүр зохион явуулж байсан ба “Их дээд сургуулиудын залуу судлаачдын судалгааны семинар” “Байгалийн судалгаа”, “Хотын ногоон ба цэнхэр дэд бүтэц”, “Хог хаягдлын технологи” сэдвүүдийн хүрээнд эрдэм шинжилгээний хурлууд цахим ба холимог байдлаар зохион байгуулагдсан.
4. Ахьсан түвшний хөтөлбөр боловсруулах ажлын хамтын ажиллагааны хүрээнд төсөлд оролцогч бүх их сургуулиудын удирдлагын хүрээнд гэрээ байгуулсан ба Монгол талын оролцогчид МУИС ба Ховд их сургуулиуд төслийн хүрээнд хамтран ажиллах гэрээ мөн байгуулсан.
5. МУИС-ий Хүрээлэн буй орчин судлал хөтөлбөрийн ахьсан түвшний хичээлүүдийг Ховд их сургуулийн ахьсан түвшний оюутнууд судалсан байна.
6. Сургалтын агуулгыг сайжруулах үүднээс Ховд их сургуулийн багш ахьсан түвшний 4 хичээлийг боловсруулсан.
7. Төслийн багийн их сургуулиудын багш нар хамтран 4 хичээлээр олон нийтэд нээлттэй цахим хичээл боловсруулсан.
8. Ахьсан түвшний хөтөлбөрийн оюутнуудын судалгааны ажлыг хамтрагч их сургуулиудын профессор багш нар хамтран удирдах боломжтой болсон.
9. Төслийн хүрээнд судалгааны семинар тогтвортой явагдаж байгаа ба энэ нь төсөл дууссан үед ч үргэлжлэн явагдах боломжтой юм. Төсөлд оролцогч их сургуулиудаас гадна өөр бусад их сургуулиуд семинарын үйл ажиллагаанд оролцож байна.
10. Ахьсан түвшний сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгааг хамтрагч их сургуулиуд нэг ижил асуулгаар авч нэгтгэн боловсруулсан.

ХОЁР:

Ховд их сургууль нь хотын ногоон байгууламжийн хөгжил, түүнийг сайжруулах хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, тэдгээртэй холбоотой сургалтын хөтөлбөр шинэчлэх, хичээлийн агуулгыг баяжуулахад чиглэсэн сургалт, судалгааны “Энэтхэг ба Монгол улсын хот суурин газрын уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх чадвар, түүнд дасан зохицох байдал: Ногоон ба цэнхэр дэд бүтэц, байгальд түшиглэсэн шийдлийг дэмжихэд чиглэсэн сургалтын хөтөлбөр, чадавх

бэхжүүлэлт, мэдээлэл харилцааны технологи ашиглалт, оролцогч талуудын хамтын ажиллагаа – URGENT /Urban Resilience and Adaptation for India and Mongolia: curricula, capacity, ICT and stakeholder collaboration to support green & blue infrastructure and nature-based solutions/ сэдэвт төслийг хэрэгжүүлэх багт хамтран ажиллах болсон. Уг төсөл нь Европын холбооны Эрасмус+ хөтөлбөрийн Дээд боловсролын чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих юм. Европын холбооны ERASMUS+ хөтөлбөрийн санхүүжилтээр Энэтхэг, Монгол улсуудад мэдээлэл харилцаа холбооны технологийг сайжруулах, боловсон хүчнийг бэлтгэх замаар уян хатан, цаг уурт ээлтэй, амьдрахад таатай орчин бүрдсэн хотыг цогцлоох үүднээс байгальд суурилсан хот төлөвлөлтийн шийдэл болон ногоон цэнхэр дэд бүтцийг дэмжихэд чиглэнэ.

Энэхүү төслийн ерөнхий зорилго нь бүс нутгийн тэргүүлэх чиглэл болох «ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН» -д тулгуурлана. Төслийн хүрээнд боловсруулах сургалтын хөтөлбөрийн агуулга, сургалтын нөөц, багшийн давтан сургалт, оролцогч талууд, шинжээчдийн сүлжээ нь ногоон ба цэнхэр дэд бүтэц /GBI/, байгальд суурилсан /NBS/ уян хатан, амьдрах чадвартай, уур амьсгалд ухаалагаар ханддаг хотуудын хөгжлийг дэмжих, чадавхийг бий болгоход чиглэгдэх болно.

Ногоон ба цэнхэр дэд бүтэц, байгальд түшиглэсэн шийдэлтэй холбоотой бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрүүдэд анализ хийж, ажил олгогчийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх, менежментийн чиглэлийг нэмж оруулах, дээд боловсролын түвшинд ашиглах модуль хичээлүүдийг бэлтгэнэ. Хичээлүүдийн агуулга нь доорх асуудлуудыг багтаана. Үүнд:

- Хотын ойн аж ахуй, үүнд экологи, хотын ногоон бүсийн менежмент, хотын хүрээлэн буй орчныг хөгжүүлэх, сурталчлах, олон талт ойн менежмент;
- Ландшафтын архитектур, фитодизайн, үүнд нээлттэй ба хиймэл гадаргуугийн бичил орчны ногоон, цэнхэр дэд бүтцийн объектуудын зураг төсөл, тохижилт үйлчилгээ;
- Экологийн болон нийгэм-улс төрийн нөхцөл байдал, түүнтэй холбоотой хүнсний аюулгүй байдлын талаархи шинжлэх ухаан, удирдлага, бодлого зэргийг багтаасан хотын пермакультур;
- Шинжлэх ухаан, технологи, дасан зохицох, багасгах, хотын байгальд суурилсан шийдлүүдийн бодлого, менежментийг багтаасан ухаалаг ногоон, цэнхэр хот төлөвлөлт;

Төслийн хүрээнд оролцогч талуудын хоорондын эрдмийн солилцоо, сургалт-судалгааны тоног төхөөрөмжийг хамтран ашиглах боломжийг бүрдүүлэх ба Европын Холбоо, Энэтхэг, Монгол

улсуудын хамтрагч байгууллагуудын хооронд сургалт-судалгааны мэдээлэл солилцох боломж бүхий хамтарсан сургалтын платформ, цахим сургалтын үйлчилгээг бий болгож, түүгээрээ дамжуулан сургалтын чанарыг сайжруулна.

Түншүүд: Төсөлд нийт 5 улсын 15 байгууллагууд хамтран ажиллана.

Энэхүү төслийн үндсэн зохицуулагчаар ХБНГУ-ын Бремений их сургууль ажиллаж байгаа бөгөөд Монгол улсаас Хот төлөвлөлт, судалгааны институт, Монгол улсын их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль, Ховд их сургууль, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн зэрэг 5 байгууллага уг төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

ХБНГУ-ын Бременийн их сургууль - төслийн зохицуулагч

Италийн Катаниагийн их сургууль, Эстонийн Тарту хот дахь Хөдөө аж ахуйн Их Сургууль, ХБНГУ-ын Мартин Лютерийн Их Сургууль

Энэтхэг улсын Жавахарлал Неругийн Их Сургууль, Нирма Их Сургууль, Пондичеррийн Их Сургууль, Кашмирын Хөдөө Аж Ахуйн Шинжлэх Ухаан ба Технологийн Их Сургууль, Хотын асуудал хариуцсан үндэсний хүрээлэн, Олон Улсын Санхүүгийн Тес-Сити байгууллагууд хамтран ажиллах болно.

Төслийн эхний жилийн үйл ажиллагааны хүрээнд ICT зуны сургалт цахимаар зохион байгуулагдаж Ховд их сургуулиас 4 багш оролцлоо.

Төслийн ажлын даалгаварын хүрээнд Хотын ногоон байгууламж, хот төлөвлөлтийн чиглэлийн бакалаврын 2, магистрийн хөтөлбөрийн 4 хичээлүүдийн агуулгын шинэчлэл хийгдэхээр бэлтгэж байна.

Залуу судлаачдын эрдэм судлалын ажлыг удирдан чиглүүлэх, эрдэм шинжилгээний ажлын хүрээг тодорхойлох үүднээс энэ чиглэлийн судлаач багш нарын нөөцийн судалгаа гарсан.

Дүгнэлт:

Их сургуулиуд дангаараа хөтөлбөр хэрэгжүүлэх биш хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж суралцагчдад олон сонголтыг бий болгох, хөтөлбөрийн давхардлыг арилгах БШУ-ны яамны чиглэлийг баримтлан ажиллахад энэ төслийн үр дүн нөлөөлөх болно.

Ховд их сургуулийн хөгжлийн төлөвлөгөө 2017-2024 бодлогын баримт бичигт хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх талаар тодорхой заасан байдаг. Энэхүү төслүүдийн үр дүн нь уг зорилгыг биелүүлэхэд тодорхой хувь нэмрийг оруулж байгаагийн зэрэгцээ багш судлаачдын хамтын ажиллагаа, хамтарсан судалгаа өргөжихөд ихээхэн үр дүнтэй байсан. Олон нийтэд нээлттэй цахим сургалтын ач холбогдлыг түгээн дэлгэрүүлэх, их сургуулиудын нийгмийн хариуцлагын хэрэгжүүлэхэд болосвруулсан хичээлүүдийн ач холбогдол оршино. Багшлах боловсон хүчнийг чадавхижуулах, залуу судлаачдыг чадваржуулах, хүний нөөцийн хөгжилд маш их ач холбогдолтой

төслүүд хэрэгжиж байна.

Цаашид төслийн тогтвортой байдлыг хадгалах, үр дүнг урт удаан хугацаанд ашиглах үүднээс төсөлд оролцогч талууд тогтвортой хамтран ажиллах нь чухал юм.

Abstract

INTENSE addresses such root causes of environmental problems in Mongolia (MN), Ukraine (UA) and Vietnam (VN), as poorly formulated policies, inadequate selection of management actions and the lack of suitable technology, by building capacity for academic excellence in doctoral training in environmental studies in PCs (and beyond). It aims:

To enhance doctoral training provision by integrating and upgrading existing learning contents that can be used for doctoral provision, infrastructure for accessing the courses and setting & monitoring flexible research training trajectories and their progression (INTENSE open education platform, including sustainable mechanisms for its development and maintenance) and shared access to research facilities. INTENSE will offer PhD students customized training trajectories and options to enrol on the courses, which will contribute to the progression of PhD theses; the IT infrastructure will provide access to the e-courses (including MOOCs) collected from all the PCs belonging to INTENSE, from the full range of disciplinary fields related to environmental policy, management and technology, and to eScience modules creating individual learning portfolio.

To build the capacity of PhD students to improve their published output, through a strengthened multidisciplinary approach to doctoral training, aided by facilitating access to global and EU research networks (including facilitation of academic mobility), development of transferable skills, promotion of joint research/supervision arrangements & interdisciplinary & practice-oriented thesis topics.

- *Development of eLearning modules and MOOCs*
- *Development of transferrable skills courses and learning materials*
- *Training events*